| 2.2.2. | Ерөнхий боловсроын сургууль, Сургуулийн өмнөх боловсрол Залуучууд, гэр бүл хөгжлийн төвүүдэд соёл, урлагийн боловсрол олгоход арга зүйн дэмжлэг үзүүлэх | Арга зүйн дэмжлэг үзүүлсэн эсэх | 2 сургалтын төвд дэмжлэг үзүүлсэн. | 2-оос доошгүй сургалтын төвд дэмжлэг үзүүлсэн байна. |  “Сургуулийн өмнөх боловсрол ба Соёлын боловсрол” хүүхдэд эх хэл, язгуур соёл, ёс заншлыг танин мэдүүлж, сургаж, бага наснаас нь монгол хүн болгон хүмүүжүүлэх зорилгоор уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2024.04.23-ны өдөр Хүүхдийн номын ордонд СоЯ, БЕГ, ИДС, 155, 147-р цэцэрлэг зэрэг оролцогч талуудыг хамруулсан уулзалт зохион байгуулагдаж нийт 20 төлөөлөл оролцож, танилцуулга хийж, сургалтын модуль, гарын авлага боловсруулах агуулга дээр санал солилцов.<br> СӨБ-ийн 60 гаруй багш, арга зүйчтэй "СӨБ-ын багш нарт үндэсний соёлын боловсрол олгох сургалтын модуль хөтөлбөр боловсруулах" уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, санал асуулга авсан.<br> "Бүх нийтийн соёлын боловсрол (2023-2024) арга хэмжээний төлөвлөгөө"-ний 5 дугаар зорилтын хүрээнд гэр бүлд зөвлөгөө | 100% | 2024.02-11 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өгөх төвөөр салбарын албан хаагчдад сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хямралыг даван туулах сургалт зохион байгуулах, хүүхдийн асран хамгаалагч тогтоох асуудлаар сэтгэл зүйн дүгнэлт гаргах зэрэг чиглэлээр “Тэвэр дүүрэн сэтгэл” ТББ-тай хамтран ажилласан. Энэ хүрээнд Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, түр хамгаалах байрны 45 ажилтан, алба хаагчдыг стресс менежментийн сургалтад хамрагдсан байна. | | |
| 2.2.3. | Нүүдлийн соёлын боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх /Хилийн чанад дахь хүүхэд багачуудад зориулсан/ | Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн эсэх | Хөтөлбөр-2 хэрэгжүүлсэн. | Нүүдлийн соёлын боловсрол олгох жишиг хөтөлбөр нэгээр нэмэгдсэн байна. |  Хилийн чанад дахь Монголчуудын хүүхэд багачуудыг зуны улиралд хүлээн авдаг “Нүүдлийн соёлын боловсрол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч “Нүүдлийн соёлын зуслан”-ийн хүүхэд багачуудыг "Нүүдэлчин дэлхийн фестиваль"-д тусгай хөтөлбөр бэлтгэн хамруулсан. Үндэсний өв соёлоо сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэн, “Нүүдлийн соёлын боловсрол” үндэсний хөтөлбөрийн үр дүнг тайлагнаж, давхардсан тоогоор 300 гаруй олон соёлт гэр бүлд танилцуулсан. Фестивальд Хэнтий аймгийн 2 салбар зуслан, Өвөрхангай аймгийн 2 салбар зуслан, Дархан, Хөвсгөл, Ховд, Төв, Дундговь аймгийн нийт 9 байршилд үйл ажиллагаа явуулж буй Нүүдлийн соёлын зусланд хамрагдсан 120 сурагч 30 багшийг оролцуулсан.<br> ТНБД-ын 2024 оны А/49 дүгээр тушаалын хэрэгжилтийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэмжлэгтэй хэрэгжиж буй "Нүүдлийн соёлын боловсрол" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Д.Содномдоржийн цомнол, Ц.Сүхбаатарын хөгжим "Аз жаргалын эрэлчин" хүүхдийн дуулалт жүжгийн уралдааны 1 дүгээр шатыг 21 аймагт зохион байгуулах ажлыг гүйцэтгүүлэхээр Дэлхийн мөрөөдлийн сургууль НҮТББ-тай ССАЖЗЯ-24/217 дугаартай гэрээ байгуулж, дэмжиж ажиллав. | 100% | 2024.02-11 |
| 2.3 “Соёлоор дамжуулан соён гэгээрүүлэх ажлыг идэвхжүүлж, үндэсний соёлын дархлааг нэмэгдүүлнэ” | | | | | | | |
| 2.3.1. | "Гэр бүл-Монгол соёлын | Зохион | - | 5-аас доошгүй |  Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сантай | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | анхдагч орчин" арга хэмжээний хүрээнд гэр бүлд зориулсан олон талт ажлыг нэмэгдүүлэх нөлөөллийн аян зохион байгуулах | байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо | | арга хэмжээ зохион байгуулж, 1000-аас доошгүй хүн хамруулсан байна. | байгуулсан хамтран ажиллах санамж бичиг болон ТНБД-ын 2024 оны А/17 дугаар тушаалын хэрэгжилтийн дагуу "Гэр бүл-соёлын анхдагч орчин" соёлын боловсрол олгох хөтөлбөрийг 2024.09.20-11.20 өдрүүдэд гэр бүл, хүүхэд багачууд болон олон нийтэд зориулан хэрэгжүүлсэн.<br>Хүүхэд, гэр бүлд чиглэсэн соёлын боловсрол олгох олон талт арга хэмжээг зохион байгуулж, хүүхдийн эрх, хөгжил, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар ойлголт мэдээллийг нэмэгдүүлэх, соёлын боловсролын сургалт, хөтөлбөрийг тогтмол хүргэх орон зайг шинээр бий болгож, нийгмийн соён гэгээрлийг дэмжих зорилготой тус хөтөлбөрийг:<br>-Монгол Улсын Үндэсний Номын сан,<br>-Монголын үндэсний музей,<br>-Чингис хаан үндэсний музей,<br>-Байгалийн түүхийн музей,<br>-Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей,<br>-Уран зургийн галерей,<br>-Улсын Хүүхэд, залуучуудын театр,<br>-Улсын Хүүхэлдэйн театр,<br>-Хүүхдийн төв номын сан<br>зэрэг 9 байгууллага 1. Музейн соёлын боловсрол хөтөлбөр, 2. Театр урлагийн боловсролын хөтөлбөр, 3. Хүүхдийн ном, зохиол тойрсон соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, 4. Хүүхэлдэйн урлал, гар урлал, 4. Уран зураг, 5. Оньсон тоглоом гэхчилэн соёл, урлагийн боловсрол олгох олон талт хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлсэн.<br>Хөтөлбөрт танхимаар 13,0 мянга гаруй хүүхэд багачууд, эцэг эх, иргэд, цахимаар 2,5М үзэлт, хандалт авсан нь хөтөлбөрийн үр дүн байлаа.<br>Хэрэгжүүлсэн хөтөлбөр-5,<br>Хэрэгжүүлсэн байгууллага -12<br> ССАЖЗЯ, Архангай аймгийн Соёл, урлагийн газар, Аймгийн Цагдаагийн газар, | 100% | 2024.02-11 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сумдын Соёлын төв хамтран "Гэр бүл-Монгол соёлын анхдагч орчин" сэдэвт сургалт, нөлөөллийн ажлыг Эрдэнэбулган, Булган, Цэнхэр, Төвшрүүлэх зэрэг нийт 15 суманд зохион байгуулж 2500 хүүхэд, 1500 насанд хүрэгчид, хөгжлийн бэрхшээлтэй 32 иргэн нийт 4032 хүн хамрагдсан. Дээрх үйл ажиллагааны үр дүнд сумдын иргэд олон нийтийн бүх нийтийн соёлын боловсрол, гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн үүрэг хариуцлагыг ойлгуулж мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн. *Зарцуулсан төсөв-87,0 сая төгрөг* | | |
| 2.3.2. | Нийгмийн бүлэгт чиглэсэн, соёлын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо | Арга хэмжээ-10 зохион байгуулсан. | 5-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 2500-аас доошгүй хүн хамруулсан байна. | "Бүх нийтийн соёлын боловсрол (2023-2024) арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн дагуу 2024 онд гэр бүлийн боловсрол олгох сургалтын 8 модуль 24 сэдвийн хүрээнд аймаг, нийслэлийн хэмжээнд 325 "Сургагч багш"-ийг бэлтгэж, сургалтын 8 модулын хүрээнд иргэдэд сургалт зохион байгуулсан.<br>"Гэр бүлд суурилсан бага насны хүүхдийн хөгжил, боловсролыг дэмжих үйлчилгээний хувилбар"-ын хүрээнд "Таблеттай багш" бэлтгэх явуулын сургалтыг Увс аймгийн Боловсролын ерөнхий газар, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сантай хамтран зохион байгуулж, Хилийн цэргийн 0245 дугаар ангийн 7 салбарын 7 багшийг бэлтгэсэн.<br>"Угийн бичиг" хөтлөхийн ач холбогдлыг олон нийтэд таниулах, өрх бүрт хөтлүүлэн хэвшүүлэх "Сургагч багш" бэлтгэх сургалтыг "Ураг удам, уламжлалын Холбоо" ТББ-тай хамтран зохион байгуулж, 21 аймаг, нийслэл, 9 дүүрэг, ТББ-ын төлөөлөл 30 иргэнийг танхимаар, орон нутгийн харьяа байгууллагын мэргэжилтэн, соёлын төв, төрийн бус байгууллагуудын төлөөлөл 60 иргэнийг цахимаар хамруулж, угийн бичиг, ургийн овог, удам судар, ёс заншил, гэр бүлүүдийн ураг төрлийн холбоог таниулж, | 100% | 2024.02-11 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ураг төрөл ойртсон гэрлэлтээс сэргийлж улмаар эрүүл саруул удамтай байх, угийн бичгийг хөтлөхийн ач холбогдлыг түгээн дэлгэрүүлж, зохих мэдлэг ойлголтыг олгосон.<br>Хүүхдийн хүмүүжил, төлөвшилд аавуудын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, модулын арга зүйг түгээн дэлгэрүүлэх, аавуудад хүргэх нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг өргөжүүлэх үүднээс "Аавуудыг чадавхжуулах нь" сэдэвт сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулж, 21 аймаг, нийслэл, дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, хэлтсийн гэр бүлийн болон хүүхдийн асуудал хариуцсан 35 мэргэжилтнийг "Сургагч багш"-аар бэлтгэсэн.<br>Мөн нийслэлийн хороодын хэсгийн ахлагч нийт 215 хүнд "Бүх нийтийн соёлын боловсрол" сургалтыг зохион байгуулж, салбар дундын зохицуулалтын хамтарсан албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллахыг чиглэл болгов.<br>Мөн бүх нийтийн соёлын боловсролын сургалтын гарын авлага эмхэтгэн хэвлүүлж, 400 гаруй оролцогчдод түгээв. Түүнчлэн өсвөр насны охидод гоо зүйн боловсрол олгох "Өөрөөрөө үлгэрлэе" зорилтот сургалтад 2200 гаруй охид, "Монгол Монголоороо" аялгуут лекцийг Улсын Хүүхэд залуучуудын театрт 2 удаа зохион байгуулж нийт 1520 залуус, морин хуурын анхан шатны сургалтад 1000 хүүхэд хамрагдаж "Ирээдүйн өвлөн уламжлагч" уулзалт зохион байгуулсан. Нийслэлийн гэр бүлд, хүүхдэд зориулсан "Гэр бүл-соёлын анхдагч орчин" соёлын боловсрол олгох хөтөлбөрийг 2 сарын хугацаатай хэрэгжүүлж, 13,0 мянга гаруй гэр бүл, хүүхэд, иргэд хамрагдсан. | | |
| 2.3.3. | "Соёлын бүтээлч сар 2024" аяныг хамтран зохион | Төсөл, арга хэмжээнд | 2 төсөл, арга хэмжээ | 2-3 төсөл, арга | ТНБД-ын 2024 оны А/49 дүгээр тушаалын хэрэгжилтийн дагуу Соёлын бүтээлч | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах | дэмжлэг үзүүлсэн эсэх | | хэмжээнд дэмжлэг үзүүлсэн байна. | үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 22.1.1, 22.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөтөлбөр, арга хэмжээ, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх хүрээнд хуулийн этгээд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран ажиллав. Үүнд:<br> Орфей театр фильм ХХК-тай Үй Хуа "Амьдрахуй" жүжгийг аймаг, орон нутгийн үзэгчдэд толилуулах ажил гүйцэтгүүлэх ССАЖЗЯ-24/233 дугаартай гэрээ,<br> Монголын моно жүжгийн төв ТББ-тай моно жүжгийн өдрүүдийг зохион байгуулж, "Би Эдит Пиаф байна" моно жүжгийг үзэгчдэд хүргэх драмын урлагийн түгээн сурталчлах ажил гүйцэтгүүлэх ССАЖЗЯ-24/218 дугаартай гэрээг тус тус байгуулан, холбогдох ажлыг гүйцэтгүүлэн хамтран ажиллав.<br>*Уралдаан-1, өдөрлөг-1, нийслэл, орон нутгийн иргэдэд уран бүтээл толилуулах үйл ажиллагаа -2*<br>*Зарцуулсан төсөв-25,0 сая төгрөг* | 100% | 2024.10-12 |
| 2.3.4. | Зорилтот бүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн эрхийг хамгаалах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх | Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээ, хамрагдсан иргэдийн тоо | - | 2 арга хэмжээ хэрэгжүүлж, 100-аас доошгүй хүнийг хамруулсан байна. |  Сайдын 2024 оны А/124 дүгээр тушаалын хэрэгжилтийн дагуу 1. Дэлхийн циркчдийн өдөрт зориулсан тоглолт 2. Орон нутгийн иргэдэд зориулсан циркийн аялан тоглолтыг зохион байгуулсан. Энэ хүрээнд асрамжийн төвийн болон хөгжлийн бэрхшээлтэй 400 гаруй хүүхэд, багачуудыг төв, орон нутгийн циркийн тоглолт, арга хэмжээнд үнэ төлбөргүй хамруулсан.<br> "Соёлын бүтээлч сар-2024" аяныг улсын хэмжээнд нэгдсэн агуулга, нэг өнгө төрхтэйгөөр зохион байгуулж байгуулсан бөгөөд аянд УДЭТ, УДБЭТ, ҮУИТ, ҮХТ, ХЗТ, УФ зэрэг мэргэжлийн урлагийн байгууллагууд урлагийн тоглолт, үзэсгэлэн, боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэн хөгжлийн бэрхшээлтэй 1267 иргэнийг урлагийн тоглолт, үзвэр үйлчилгээнд хамруулсан. | 100% | 2024.02-11 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | □ Монгол Улсын Төрийн соёрхолт “Харанга” хамтлагийн 35 жилийн ойн аялан тоглолтыг зүүн бүсийн иргэдэд толилуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан. “Харанга-35” тоглолт Дархан-Уул, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн 4000 гаруй үзэгчдэд хүрснээс зорилтот бүлгийн 390 орчим иргэн хамрагдсан. | | |
| 2.3.5. | Соёлын салбарын Залуучуудын хөгжлийг дэмжих, салбарын хөгжилд залуусын оролцоо манлайллыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээ хамрагдсан иргэдий тоо | Сургалт, нөлөөллийн арга хэмжээ-2 | Сургалт, нөлөөллийн 3 арга хэмжээ зохион байгуулсан байна. | □Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/49 дүгээр хамтран ажиллах тухай албан бичгийн дагуу салбар дундын болон орон нутгийн залуучуудын салбар зөвлөлүүдийн хамтын үйл дэмжих, залуусын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хүн бүр үнэ цэнтэй” TEDxUlaanbaatar арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Төрийн Ордонд зохион байгуулсан ба салбарын төлөөлөл Соёлын яамны Залуучуудын хөгжлийн зөвлөл, Сүхбаатар аймгийн Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөл оролцсон.<br>□ Төв аймгийн Соёлын салбарын залуу албан хаагчдын зөвлөгөөнд 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгулагдаж, “Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагаа”-ны талаар танилцуулга мэдээлэл хийж, орон нутгийн соёлын салбарын хөгжлийн зөвлөлийн залууст тулгамдаж буй асуудал, зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр санал солилцсон.<br>□Соёлын яам, Хил хамгаалах Хилийн цэргийн Ерөнхий газар, дугаар ангийн Дэд хурандаа, Хошууч, Ахлах офицер нарт Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа болсон язгуур соёл, өв уламжлал, төрт ёсны түүхээ дээдлэн хамгаалж, таниулан сурталчлах, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр баримталж буй бодлого, төрийн албан бичиг | 100% | 2024.02-11 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баримтыг хуульд нийцүүлэн хэтлөх, төрөлх монгол хэл, бичгээрээ зөв ярьж, бичих, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ын хэрэгжилт болон холбогдох хууль, тогтоомжуудын талаар нийт 40 албан хаагчдад Үндэсний номын сан дээр мэдээлэл зөвлөгөө өгсөн. | | |
| 2.3.6. | Мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, чиг үүргийг гүйцэтгүүлэх | Монголын циркчдийн холбоонд дэмжлэг үзүүлсэн эсэх | - | 2-оос доошгүй холбоодод дэмжлэг үзүүлсэн байна. | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх "Гэрээ байгуулах тухай" Засгийн газрын 2008 оны 61 дүгээр тогтоолын хэрэгжилтийн дагуу сайдын 2024 оны "Циркийн уран бүтээлчдийн эрх ашиг, нийгмийн баталгааг хангах, бүртгэх, статистикийн мэдээлэл боловсруулах, циркийн урлагийг гадаад, дотоодын иргэд, байгууллагад сурталчлах чиг үүргийг гүйцэтгүүлэх" А/124 дүгээр тушаал батлагдсан. Тушаалын хэрэгжилтийн дагуу Монголын циркчдийн холбоо ТББ-тай "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулан холбогдох чиг үүргийн ажлыг гүйцэтгүүлэн, ажлын тайланг хүлээн авч, гэрээг дүгнэх акт үйлдсэн. *Зарцуулсан төсөв-15,0 сая төгрөг* | 100% | 2024.02-11 |
| 2.3.7. | Төрийн шагналт, Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин Л.Цогзолмаагийн 100 насны ойн хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах | Арга хэмжээг зохион байгуулсан эсэх | - | 3-аас доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байна. | Сайдын 2024 оны А/59 дүгээр тушаалаар Төрийн шагналт, Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин Л.Цогзолмаагийн 100 насны ойн хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан. Ойн хүрээнд 1. Ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал, 2. Ойд зориулсан “Бөмбөгөр ногооноос эхэлсэн Цоохоо” амьдрал, уран бүтээл фото үзэсгэлэн 3. Л.Цогзолмаагийн “Олны хүч – оломгүй далай” амьдрал, уран бүтээл болон дурсамж дуртгалууд номыг шинэчлэн хэвлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан. *Зарцуулсан төсөв-20,0 сая төгрөг* | 100% | 2024.09-10 |
| 2.3.8. | Соёлын сэргэлт-2024 арга хэмжээг зохион байгуулахад дэмжин ажиллах | Арга хэмжээний тоо | - | 100% | "Соёлын сэргэлт 2024" аяны хүрээнд соёлын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулагдсан бөгөөд зөвлөгөөний зохион байгуулалтад ажиллаж, | 100% | 2024.05-06 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүндэтгэлийн арга хэмжээ, урлагийн тоглолтыг зохион байгуулсан. Мөн сайдын 2024 оны А/194 дүгээр тушаалаар "Соёлын сэргэлт 2024" аяны арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах "Зардал баталж, эрх шилжүүлэх тухай" тушаалыг батлуулан УДЭТ, УДБЭТ, ҮУИТ, УХТ, УФ, НСУГ зэрэг байгууллагад дэмжлэг үзүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан.<br>*Зарцуулсан төсөв-120,0 сая төгрөг* | | |
| 2.4. "Салбарын бодлогыг тэгш хүртээмжтэй хэрэгжүүлж, үндэсний болон олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд хүргэнэ" | | | | | | | |
| 2.4.1. | Аймаг, нийслэлийн театруудын дунд 2 жил тутам зохион байгуулагдах мэргэжлийн урлагийн улсын уралдааныг зохион байгуулах | Дэмжлэг үзүүлсэн эсэх | - | Театруудын улсын уралдаан зохион байгуулагдсан байна. | Орон нутгийн театруудын урын санг үндэсний, сонгодог, орчин үеийн уран бүтээлээр баяжуулж, уран бүтээлчдийг чадавхжуулах, бүтээлч өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох зорилготой "Шилдэг бүтээл, шилдэг уран бүтээлч" шалгаруулах театрын уралдааныг зохион байгуулах сайдын 2024 оны А/65 дугаар тушаал батлагдсан. Тушаалын хэрэгжилтийн дагуу ЗГХА Соёл, урлагийн газар, Монголын урлагийн ажилтны холбоо ТББ-тай хамтран улсын уралдааныг зохион байгуулсан. Уралдаанд орон нутгийн 16 Хөгжимт драмын театр бүс нутгаараа нэгдэн, цогц уран бүтээл туурвиж оролцсоноороо онцлог байлаа. Уралдааны эцсийн шалгаруулалт, гала тоглолт 2024 оны 12 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан бөгөөд шилдэг бүс 20,0 сая төгрөгийн мөнгөн шагнал хүртсэн юм.<br>*Оролцсон байгууллага - 16 Хөгжимт драмын театр,*<br>*Хамрагдсан уран бүтээлч, ажилтан- 800 гаруй*<br>*Шалгаруулалт 4 бүсээр - төв, баруун, зүүн, хойд*<br>*Гала тоглолт-1*<br>*Зарцуулсан төсөв-70,0 сая төгрөг* | 100% | 2024.10-12 |
| 2.4.2. | Олон улсын хэмжээнд зохиогддог соёл, урлагийн | Тогтоолын төсөл | - | Тогтоолын төслийг | □ Монакогийн Вант Улсын Монте Карло хотод зохион байгуулагддаг "Монте Карло - | 100% | 2024.01-06 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | их наадам, уралдаан үзэсгэлэн, номын яармагт оролцож, онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох | боловсруулж, батлуулж, мөнгөн шагнал олгосон эсэх | | Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, мөнгөн шагнал олгосон байна. | 46" дэлхийн циркчдийн их наадамд "Трүүп Амараа" хамтлагийн уран бүтээлчид "Хүннү гүрэн" бүтээлээр оролцон "Мөнгөн алиалагч" цомын эзэд болсон. Дээрх уран бүтээлчдэд "Мөнгөн шагнал олгох тухай" Засгийн газрын 2024 оны 135 дугаар тогтоолыг боловсруулж, батлуулан, сайдын 2024 оны А/193 дугаар тушаалаар 40,0 сая төгрөгийн мөнгөн шагналыг олгосон;<br> Бүгд Найрамдах Унгар Улсын Будапешт хотод зохиогдсон "Будапешт циркийн фестиваль" олон улсын циркчдийн уралдаанд "Трүүп Зола" хамтлагийн уран бүтээлчид шинэ уран бүтээлээр оролцож "Алтан цом" хүртсэн. Дээрх уран бүтээлчдэд "Мөнгөн шагнал олгох тухай" Засгийн газрын 2024 оны 186 дугаар тогтоолыг боловсруулж, батлуулан, сайдын 2024 оны А/248 дугаар тушаалаар 24,0 сая төгрөгийн мөнгөн шагналыг олгосон.<br>*Тогтоол-2*<br>*Зарцуулсан төсөв-64,0 сая төгрөг* | | |
| 2.4.3. | "Мөнгөн мод" оны шилдэг уран бүтээл, уран бүтээлч шалгаруулах арга хэмжээнд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх | Журмын хэрэгжилтийг хангасан эсэх | 2023 онд "Мөнгөн мод" оны шилдэг уран бүтээл, уран бүтээлч шалгаруулах наадамд дэмжлэг үзүүлсэн. | Шилдэг уран бүтээлч, уран бүтээл шалгарсан байна. | Соёлын сайдын 2024 оны А/53 дугаар тушаалаар Соёл, урлагийн салбарын оны шилдэг уран бүтээл, уран бүтээлчийг шалгаруулах "Мөнгөн мод 2023" наадмын удирдамж, наадмыг зохион байгуулахад шаардагдах зардал батладсан. Удирдамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдаж шилдэг уран бүтээл болон уран бүтээлчийг шалгаруулсан. Түүнчлэн сайдын 2024 оны А/123 дугаар тушаалаар Соёл, урлагийн салбарын 2023 оны шилдэг бүтээлийг олон нийтэд хүргэх, сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах зардлыг батлуулсан.<br>Наадамд 216 уран бүтээлч өрсөлдсөнөөс соёлын өв, ном хэвлэл, дуу хөгжим, тайзны урлаг, дүрслэх урлаг, кино урлаг, нийтлэл нэвтрүүлэг, цахим бүтээл, архитектур, хувцас загвар, зар сурталчилгаа, дизайн гэсэн 12 төрлөөр шилдэг бүтээлийг, | 100% | 2024.03-04 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | найруулагч, зураач, зохиолч, хөгжмийн зохиолч, продюсер, удирдаач, бүжиг дэглээч, жүжигчин, хөгжимчин, дуучин, бүжигчин, судлаач, гэрэл зурагчин гэсэн 13 төрлөөр шилдэг уран бүтээлчдийг шалгаруулж, мөнгөн шагнал, "Мөнгөн мод" цом гардуулсан. *Зарцуулсан төсөв-180,0 сая төгрөг* | | |
| 2.4.4. | Төв, орон нутгийн театр, чуулгын уран бүтээлд дэмжлэг үзүүлэх | Дэмжлэг үзүүлсэн эсэх | - | 100% | Сайдын 2024 оны А/256 дугаар тушаалаар "Монголын түүх, соёлын өв, зан заншлыг хүүхэд, багачуудад таниулан сурталчлах, үндэсний соёлоор бахархах үзлийг бий болгох зорилго бүхий "Эзэн богдын бага нас" хүүхэлдэйн жүжгийг бүтээх, түгээх, Соёлын төв, соёлын ордны орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага стандартын хэрэгжилтийг хангах"-д дэмжлэг үзүүлсэн. *Зарцуулсан төсөв-82,5 сая төгрөг* | 100% | 2024.02-11 |
| 2.4.5. | "Сонгодог урлаг-III" арга хэмжээг бодлого зохицуулалтаар хангах | Арга хэмжээний 3 дугаар үе шатыг бүрэн хэрэгжүүлсэн эсэх | - | 50% | 1. "Сонгодог урлаг III" арга хэмжээний биелэлтийн хүрээнд "Алслагдсан сум, дүүргийн иргэдэд сонгодог урлагаар үйлчлэх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх"-ээр зорилгоор Монгол Улсын Консерваторын симфони найрал хөгжим болон сонгодог бүжгийн багш, оюутнууд 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Төв аймгийн Монгол туургатан театрын тайзнаа "Уран хас" бүжгэн жүжгийг аймгийн хүүхэд, залуучуудад толилуулахад зохион байгуулалтын дэмжлэг үзүүлсэн.<br>2. Монгол Улс, Бүгд Найрамдах Узбекистан Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 32 жилийн ойн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх тус улсад 2024 оны 6 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд төрийн айлчлал хийсэн.<br>Айлчлалын хүрээнд "Узбекистан" олон улсын чуулга уулзалтын ордонд Монгол | 100% | 2024.02-11 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улсын Филармонийн Морин хуурын найрал хөгжмийн уран бүтээлчид бүрэн бүрэлдэхүүнээрээ болон ДБЭТ-ын гоцлол дуучин Б.Энхнаран, БНУУ-ын Үндэсний найрал хөгжмийн уран бүтээлчид, ардын дуучид, бүжигчдийн хамтарсан хүндэтгэлийн тоглолтыг зохион байгуулсан.<br>Хүндэтгэлийн тоглолтыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайд С.Амарсайхан, Бүгд Найрамдах Узбекистан Улсын Шадар сайд Ж.Ходжаев нар нээсэн бөгөөд урилгаар хоёр талын төр, засгийн удирдлага, гадаад улсаас тус улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон олон улсын байгууллагуудын суурин төлөөлөгчийн газруудын тэргүүн нар зэрэг нийт 1000 орчим үзэгч үзэж сонирхов.<br>Энэхүү хүндэтгэлийн тоглолт нь соёлын өв, уламжлалт урлагаараа дамжуулан Монгол Улсаа олон улсад сурталчлан таниулах ач холбогдолтой болсон бөгөөд Монгол, Узбекистан хоёр улсын соёл, урлагийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсныг талууд онцлов.<br>3. 2024 оны 8 дугаар сарын 03-ны өдөр УДБЭТ-ын "Centennial Celebration" сонгодог концертод дэлхийн өнөө цагийн ноён оргилуудын нэг П.Доминго болон МУАЖ Э.Амартүвшин, Ф.Сартори, Нина Минасян, Г.Ло Коко, УДБЭТ-ын яруу тунгалаг найрал хөгжим оролцон тоглоход дэмжлэг үзүүлсэн. | | |
| 2.4.6. | Орон нутгийн театр, чуулгад хүүхдийн уран бүтээлийн франчайзинг нэвтрүүлэх | Франчайзинг нэвтрүүлэн театр, чуулга, соёлын төвийн тоо | - | 100% | Сайдын 2024 оны А/200 дугаар тушаалаар "Монгол Улсын хүүхэлдэйн театрын урын сан дахь бүтээлийг орон нутгийн театр, чуулга, соёлын төвд нэвтрүүлэх зорилгоор зардал баталж, эрх шилжүүлэх тушаал батлагдсан. Энэ хүрээнд 1. Завхан аймгийн | 100% | 2024.03-10 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ХДТ 2. Дундговь аймгийн Тэнгэрийн тэмдэг театр 3. Баянхонгор аймгийн Галуут сумын соёлын төв 4. Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын соёлын төв 5. Баянхонгор аймгийн Тэмүүжин театр 6. Хэнтий аймгийн Баян-Овоо сумын соёлын төв 7. Дархан-Уул аймгийн Орхон сумын соёлын төвд франчайзингийг нэвтрүүлсэн.<br>*Зарцуулсан төсөв-20,0 сая төгрөг* | | |
| 2.4.7. | Хүүхэд, залуучуудын театрын нээлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангах | Нээлтийн төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг хангаж ажилласан эсэх | Засгийн газрын 2021 оны 158 дугаар тогтоол ХЗТ-ын дүрэм, бүтэц | 100% | Хүүхэд, залуучуудын театрын бүтээн байгуулалт бүрэн дуусаж, 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр олон улсын стандартад нийцсэн, 850 хүний багтаамжтай шинэ театр нээлтээ хийсэн.<br>Тус театрын барилга нь нийт 12900 мкв талбай бүхий 3 давхар, их бага танхим, дуу бичлэгийн студи, видео студи, кофе шоп, ресторан болон дугуйлан сургалтын үйл ажиллагаа явуулж хүүхэд залуучуудад зориулсан мэргэжлийн уран бүтээл туурвих төдийгүй соён гэгээрлийн олон талт үйл ажиллагаа явуулах төв болж байгаа юм.<br>Энэхүү театр нь Сонгинохайрхан дүүргийн 341 мянган иргэний төдийгүй нийт Монгол Улсын хүүхэд, залуучуудын оюуны хөгжил, гоо зүйн боловсрол, дэлхийн театр урлагийн хөгжлөөс суралцах, үндэсний урлагийг өвлөн уламжлуулах, уран сайхны олон талт чиг хандлагыг танин мэдэх боломжийг нээж, бүх нийтийн соёлын боловсролыг дэмжих, хамтдаа сурч, хөгжих соёлын орон зай юм.<br>Нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах болон шинэ уран бүтээлүүд туурвих, тоног төхөөрөмж, бараа материал худалдан авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор сайдын А/430 дугаар тушаал, А/195 дугаар тушаалаар 810 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Нээлтэд 1200 гаруй иргэд, хүүхэд багачууд оролцсон. | 100% | 2024.03-05 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | *Зарцуулсан төсөв-810,0 сая төгрөг* | | |
| 2.4.8 | Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын барилгын хүчитгэл, их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | Сэргээн засварлалтын гүйцэтгэлийн хувь | Засварын ажил 70 хувь | Засварын ажлыг бүрэн дуусгаж, хүлээлгэн өгсөн байна. |  Улсын драмын театрын барилгын их засварын ажил 100% дууссан болно.<br> Дуурь бүжгийн эрдмийн театрын их засварын ажил 90%-тай хэрэгжсэн. Улсын комиссын дүгнэлт гараагүй байна. | 100% | 2024.01-12 |
| 2.4.9 | Салбарын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төв, орон нутгийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэх | Ашиглалтад орох барилгын тоо, Батлуулсан зураг төслийн тоо | - | Театр-3 |  Хүүхэд, залуучуудын театрын бүтээн байгуулалт бүрэн дуусаж, 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр олон улсын стандартад нийцсэн, 850 хүний багтаамжтай шинэ театр нээлтээ хийсэн.<br>Тус театрын барилга нь нийт 12900 мкв талбай бүхий 3 давхар, их бага танхим, дуу бичлэгийн студи, видео студи, кофе шоп, ресторан болон дугуйлан сургалтын үйл ажиллагаа явуулж хүүхэд залуучуудад зориулсан мэргэжлийн уран бүтээл туурвих төдийгүй соён гэгээрлийн олон талт үйл ажиллагаа явуулах төв болж байгаа юм.<br>Энэхүү театр нь Сонгинохайрхан дүүргийн 341 мянган иргэний төдийгүй нийт Монгол Улсын хүүхэд, залуучуудын оюуны хөгжил, гоо зүйн боловсрол, дэлхийн театр урлагийн хөгжлөөс суралцах, үндэсний урлагийг өвлөн уламжлуулах, уран сайхны олон талт чиг хандлагыг танин мэдэх боломжийг нээж, бүх нийтийн соёлын боловсролыг дэмжих, хамтдаа сурч, хөгжих соёлын орон зай юм.<br>Нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах болон шинэ уран бүтээлүүд туурвих, тоног төхөөрөмж, бараа материал худалдан авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор сайдын А/430 дугаар тушаал, А/195 дугаар тушаалаар 810 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Нээлтэд 1200 гаруй иргэд, хүүхэд багачууд оролцсон.<br> Увс аймгийн Улаангом сумын “Ойрад” хөгжимт драмын театрын барилгыг 2024 оны IV улиралд багтаан ашиглалтад | 100% | 2024.01-12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оруулахаар холбогдох ажлыг эрчмжүүлж байна. Театрын барилгын бүтээн байгуулалт 98%-тай явагдаж байна.<br> Завхан аймгийн Улиастай сумын 800 суудалтай Хөгжимт жүжгийн театрын барилгын ажил 95%-тай явагдаж байгаа бөгөөд 2024 оны IV улиралд багтан ашиглалтад орно. | | |
| 2.4.10. | Мэргэжлийн урлагийн байгууллагуудын тоглолтыг бүс нутаг, олон улсад зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | Дэмжлэг үзүүлсэн эсэх | - | - | Төв, орон нутгийн театр, чуулгын бүс нутаг болон олон улсад өрсөлдөх уран бүтээлд дэмжлэг үзүүлэх хүрээнд сайдын 2024 оны А/50 дугаар тушаалар "Ойрадын түүх, соёлын өвийг таниулан сурталчилсан бүрэн хэмжээний үндэсний бүжгэн жүжиг" бүтээхэд 150,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>*Зарцуулсан төсөв-150,0 сая төгрөг* | 100% | 2024.02-11 |
| **ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 3.1.1. | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх. | Баримт бичиг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх | - | 50% | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажилласан. Мөн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн болно. | 100% | 2024.01-12 |
| 3.1.2. | Иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдол, санал хүсэлтийг хариуцсан чиг үүргийн хүрээнд хуулийн дагуу шийдвэрлэх, зохих арга хэмжээ авах | Ирүүлсэн баримт бичгийн тоо, шийдвэрлэсэн эсэх | - | 50% | - Иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 103 албан бичгийг хугацаанд нь хуулийн хүрээнд шийдвэрлэн, зохих арга хэмжээг авч ажилласан.<br>- 51 албан бичгийг боловсруулан холбогдох байгууллагууд руу хүргүүлсэн.<br>- Иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 4 өргөдлийг шийдвэрлэсэн. | 100% | 2024.01-12 |
| **ДӨРӨВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | | |

| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1. | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулах сургалтад хамрагдах | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулах сургалтад хамрагдах | - | Цахимаар болон танхимаар сургалтад хамрагдсан байна. | "Төрийн албан хаагчийн хөгжил хамгаалал" хэлэлцүүлэг сургалтад хамрагдсан.<br>- Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтад 3 удаагийн сургалт, - Төрийн албаны зөвлөлөөс "Албан тушаалын хүчин зүйлийн үнэлгээ" судалгаа сургалт, - Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт,<br>- Төрийн жинхэнэ албан хаагчийн хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд багтан шинэчлэн мэдүүлэх болсонтой холбогдуулсан сургалтад цахимаар тус тус хамрагдсан. | 100% | 2024.01-12 |
| 4.1.2. | Бусад төрийн байгууллага болон яамнаас зохион байгуулах сургалтад хамрагдах | Бусад төрийн байгууллага болон яамнааѕ зохион байгуулах сургалтад хамрагдах | - | Цахимаар болон танхимаар сургалтад хамрагдсан байна. | - "Стандартчиллын суурь асуудлууд" сэдэвт сургалт<br>- Монгол Улсын урлаг соёлын мэргэжилтнүүдийн статусыг дэмжих, чадавхыг бэхжүүлэх сургалт<br>- Сонгуулийн ерөнхий хорооноос мэдээлэл өгөх цахим сургалт,<br>- "Эйбл" систем ашиглалтад орохтой холбоотой зохион байгуулсан сургалт,<br>- "Төрийн болон албаны нууцын тухай хууль анхаарах асуудал"-аар Тагнуулын Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтад тус тус хамрагдав.<br>- Мөн хувиараа англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор "Wall street in English" сургалтын төвд суралцаж байна. | 100% | 2024.01-12 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**
Соёл, урлагийн боловсрол хариуцсан мэргэжилтэн ............ / У.Одонтуяа / 2024.

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

---o0o---

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# СОЁЛ УРЛАГИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН УТГА ЗОХИОЛ, НОМ ХЭВЛЭЛ, ЭХ ХЭЛ, БИЧГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А.АЛТАНЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Үндэсний бичиг, соёлын жил-2024 арга хэмжээг салбарын хэмжээнд зохион байгуулна.<br>АХ-1.3, МУХТЖҮЧ-1.3, ЗГҮАХХТ-2.6.2.2, СТ-4.2 | Арга хэмжээний тоо<br>Хамрагдсан хүний тоо | - | Төлөвлөгөө -1,<br>Албан бичиг-1 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаас 2024 оныг “Үндэсний бичиг, соёлын жил” болгон зарласантай холбогдуулан үндэсний бичиг, соёлын түүхэн ой, арга хэмжээ, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурал зэрэг олон нийтэд сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх хүрээнд “ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛЫН ЖИЛ-2024” агуулын мөн чанар, үнэ цэн, харагдах байдал лого, өнгө, дүрслэл гэх мэт бүхий л элементүүдийг агуулсан, уран бичлэг болон бусад техникүүдийг ашиглан зураг, дүрс, текстийг зурах буюу дижитал хэлбэрт буулгасан брэндбүүк хийлгэсэн. Үндэсний бичиг, соёлын жилийг салбарын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх Үндэсний бичгийн нийтийн хэрэглээний орчин бүрдүүлэх, олон нийтэд сурталчлах, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэмдэглэн өнгөрүүлэх 3 зорилтын хүрээнд нийт 9 арга хэмжээг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, харьяа байгууллага, соёл урлагийн газруудад Соёлын дэд сайдын (хуучин нэршлээр) 2024 оны 2/979 албан бичгээр чиглэл өгч Үндэсний бичиг үсгийн баяр, Үндэсний бичиг, соёлын өдрүүд-Номын баяр арга хэмжээг уялдуулан хүүхэд, залуучуудын бүтээлч идэвх, оролцоог нэмэгдүүлэх олон талт арга хэмжээ 300 гаруй үйл ажиллагаанд танхимаар 97948 иргэн хамруулж, цахимаар 1 сая гаруй хүнд хүрсэн.<br>**Төлөвлөгөө-1**<br>**Арга хэмжээ-9**<br>**Хамрагдсан хүн-97,948** | | |
| | Дэд арга хэмжээ 1.1.1. Үндэсний бичиг соёлын жилийг салбарын хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөө батлуулж, харьяа байгууллагууд болон аймаг нийслэлийн СУГ-т хүргүүлсэн байна. | Төлөвлөгөө боловсруулсан эсэх | - | Төлөвлөгөө-1 | Үндэсний бичиг, соёлын жилийг салбарын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх “Үндэсний бичиг соёлын жил-2024” төлөвлөгөө боловсруулсан ба МУҮНС-д Үндэсний бичиг, соёлын жилийн нээлт болон брэндбүүк бүтээх зардлыг Соёлын сайдын “Зардал баталж, эрх шилжүүлэх тухай” А/120 дугаар тушаалаар шилжүүлсэн.<br>“Үндэсний бичиг соёлын жил-2024” төлөвлөгөө болон үндэсний бичиг, соёлыг сурталчилсан олон төрлийн арга хэмжээнд ашиглагдах брэндбүүкийг харьяа байгууллага, соёл урлагийн газруудад Соёлын дэд сайдын 2/979 албан бичгээр хүргүүлж, 21 аймгийн Соёл урлагийн газар болон, харьяа байгууллагууд Үндэсний бичиг үсгийн баяр, Үндэсний бичиг, соёлын өдрүүд-Номын баяр арга хэмжээг уялдуулан хүүхэд, залуучуудын бүтээлч идэвх, оролцоог нэмэгдүүлэх олон талт арга хэмжээ аймаг сумандаа зохион байгуулахдаа уг брэндбүүкийг ашигласан.<br>**Төлөвлөгөө-1** | 01.01-12.10 | 100 |
| 2. | Арга хэмжээ 1.2. Үндэсний бичиг үсгийн баярыг зохион | Зохион байгуулс | Үндэсний бичиг | Арга хэмжээ | “Үндэсний бичиг, үсгийн баяр-2024” арга хэмжээг харьяа байгууллагууд болон аймаг нийслэлийн соёл | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулахад нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.<br>АХ-1.3, МУХТЖҮЧ-1.3, ЗГҮАХХТ-2.6.2.2, СТ-4.2 | ан арга хэмжээний тоо<br>Хамрагдсан хүний тоо | үсгийн баяр - 2023 | 4-5<br>Хамрагдсан хүн-1000 | урлагийн газрууд хүүхэд, залуучуудын бүтээлч идэвх, оролцоог нэмэгдүүлэх уралдаан, тэмцээн, үзэсгэлэн, сургалт 60 гаруй үйл ажиллагааг зохион байгуулж, 10,000 гаруй иргэдийг хамруулан үндэсний бичиг, соёлоо олон нийтэд сурталчлан түгээн дэлгэрүүлсэн. Тухайлбал: Монгол Улсын Үндэсний номын сангийн Үнэт ховор номын музейд “ЮНЕСКО-д бүртгэлтэй монгол өв” бичиг соёлын үзэсгэлэн, “Үндэсний бичиг, соёлын гайхамшигт дурсгалууд” үзэсгэлэнг олон нийтийн хүртээл болгож, "Монгол Улсын Үндэсний номын сан дахь монгол бичгийн өв" номын нээлт, "Монгол бичгийн цахим бичвэр-III" улсын уралдаанд 118 хүн оролцсон. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургуулийн багш, суралцагчдын дунд “Үндэсний бичиг бидний бахархал” сэдэвт улсын III уралдаан зарлаж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургуулиудын 60 гаруй хувь буюу 28 сургуулийн 54 суралцагч, 27 багш оролцсон. “Чингисийн чулууны бичиг”, “Дуутын хар чулууны бичээс”–ийг хэн сайн мэдэх вэ? сэдэвтэй бүтээлийн уралдаанд төмөр, даавуу, чулуу, хурганы арьс гэх зэрэг олон төрлийн материал ашиглан Чингисийн чулууны бичиг, Дуутын хар чулууны бичээсийг сонирхолтой хэлбэрээр илэрхийлсэн 47 бүтээл ирүүлснийг Чингис хаан Үндэсний музейд үзэсгэлэн дэлгэж, 300 гаруй хүмүүст толилуулав. “Төрөлх монгол хэл” уран бичлэгийн улсын есдүгээр уралдаан, Монгол бичгийн тэргүүний уншигч шалгаруулах улсын арваннаймдугаар уралдаан зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, Хүүхдийн төв номын сантай хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээг 2024.05 сарын 04-05-ны өдрүүдэд Зайсан Хилл цогцолборт зохион байгуулж, 21 аймгийн 208 хүүхэд оролцсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцах эрхийг тэгш хангах зорилтын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулна.<br>АХ-1.3, МУУХХБ-1.2,1.4, СТХ-8.5, СТ-4.3 | ан эсэх | 2022 онд Бага анги, 2023 онд Дунд ангийн хүүхдэд зориулсан цахим сан бүрдүүлсэн. | боловсруулж бэлтгэл хангасан байна. | тохирсон хэлбэрээр цахим толь бичиг бүтээх ажилд хамтран оролцохоор Соёлын сайдын 2024 оны “Зардал батлах тухай” А/270 тушаалаар төсвийг шийдвэрлэн “Лэнд-Арт” ХХК-тай Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан тус толь бичгийн “Үндэсний утга агуулгатай үг хэллэг” сэдвийн 1090 үгийн зургийн сан, аудио санг бүрдүүлсэн.<br>**Тушаал 1**<br>**Цахим сан-1090 үгийн зургийн сан, аудио сан**<br>**Төсөв 20.0** | | |
| 6. | Арга хэмжээ 1.6. Хүүхэд залуучуудын эх хэлний боловсролд зориулсан монгол хэл бичиг сурахад чиглэсэн аппликейшн шинэчлэн хөгжүүлнэ.<br>АХ-1.3, МХТХ-14.1.1, ЗГҮАХ-2.6.2.2, СТ-4.2, 9.2 | Аппликейшн шинэчлэн хөгжүүлсэн эсэх | Алтан гадас үлгэрийн аппликейшн | Тушаал-1, Гэрээ-1 | Монгол хэл бичиг, сурах боломжийг нас сэтгэхүйн онцлогт нь тохирсон сонирхолтой хэлбэрээр хүүхэд багачуудад эзэмшүүлэх зорилгоор бүтээсэн “Алтан гадас” үлгэрийн аппликейшныг 10 үлгэрээр баяжуулан нэмэлт хөгжүүлэлт хийхээр “Ажлын удирдамж” ТНБД-р батлуулан, Соёлын сайдын 2024 оны 03 сарын 18-ны өдрийн “Зардал батлах тухай” А/110 тушаалаар “Хан төгс ур” НҮТББ-тай 2024.03.26-ны өдрийн Соя-24/28 дугаар “Ажил гүйцэтгэх” гэрээ байгуулсан.<br>“Алтан гадас” үлгэрийн аппликейшныг Эмтэрхий аяга, Халуун хятай, Тэмээ эвэргүй болсон нь, Хөхөө Намжил, Хоридай мэргэн, Субашидын 146 дугаар бадгийн тайлбар үлгэр, Онгироо ухна, Цэцэн тэнэг хоёр түшмэл, Тахиа үүрээр донгоддог болсны учир, Болдоггүй бор өвгөн гэсэн нэртэй 10 үлгэрийг сонгон авч үндэсний бичгээр хөрвүүлэх, өнгөт болон хөдөлгөөнт зураг, үлгэрийг дагаж уншсан дуу хоолойн бичлэг, мэдлэг бататгах сонирхолтой дасгал, сорил зэргээс бүрдсэн агуулгаар баяжуулан 2023 онд баяжуулсан нутгийн аялгууны 5 үлгэрийн аудио-г халх аялгуугаар уншуулан хөгжүүлэлтийг хийсэн.<br>**Тушаал 1**<br>**Гэрээ 1**<br>**Төсөв 14,910,740.0** | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Арга хэмжээ 1.7. Үндэсний бичгээр уламжлан ирсэн бичгийн дурсгалыг цахим хэлбэрээр түгээн, үндэсний бичгийн нийтийн хэрэглээний орчин бүрдүүлнэ.<br>АХ-1.3, ЗГҮАХ-2.6.2.2, СТ-4.2 | Нийтийн хүртээл болгосон эсэх | Цахим гарын авлага – 10 ш | Цахим хэрэглэгдэхүүн -1 | Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран “ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол Улсаас олон улсын, бүс нутгийн өвд бүртгэгдсэн өвүүдийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор нийт 7 өв (“ЛУ АЛТАН ТОВЧ”, “ЕСӨН ЭРДЭНИЙН ГАНЖУУР”, “МОНГОЛ ШУНХАН ДАНЖУУР” “САХИУСАН ДАРА ЭХ”, “МЭРГЭД ГАРАХЫН ОРОН СУДРЫН МОДОН БАР”, “ДАНЖУУРЫН ГЭРЭЛТ ХӨШӨӨ”, “ЦОГТЫН ХАДНЫ БИЧЭЭС”)-ийн танилцуулга контентыг англи монгол хоёр хэлээр бэлтгэж, цахим орчинд түгээв.<br>**Контент-7**<br>**Төсөв-10.0** | 01.01-12.10 | 100 |
| 8. | Арга хэмжээ 1.8. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3” хэрэгжилтийг ханган ажиллаж, Хос бичигтэн байгууллага шалгаруулсан байна.<br>АХ 2050-1.3.10 МУХБЗ 1.3 СТ 4.2 | Хос бичигтэн байгууллага нэмэгдсэн эсэх | Хос бичигтэн байгууллага шалгаруулалт-2 Сургалт-2 | Сургалт -1 | Соёлын салбарын төрийн албан хаагчдад төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх, бие даан суралцах 18 цагийн видео хичээл, компьютерт үндэсний бичгээр шивэх 66 заавар контент боловсруулан https://www.youtube.com/@Khosbichigten Хос бичигтэн юүтүүб суваг нээн нээлттэй байршуулж, албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгээ дээшлүүлэх бие даан суралцах нөхцөлийг бүрдүүлсэн.<br>ТНБД-ын 2024.03.15-ны өдрийн А/29 тушаалаар яамны харьяа байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр зэрэгцүүлэн хөтлөх, үндэсний бичгээр компьютерт шивэх суурь мэдлэг олгох сургалт зохион байгуулсан.<br>Соёлын яам, Хил хамгаалах Ерөнхий газрын хамтын ажиллагааны хүрээнд 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Хилийн цэргийн ангиудын захиргаа хариуцсан дэд хурандаа, хошууч, ахлах офицер нар нийт 40 алба хаагчдад соёлын салбарын хэл бичгийн бодлого, Монгол хэлний тухай болон “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ын хэрэгжилт, Хос бичигтэн хөтөлбөрийн талаар | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | танилцуулан сургалт зохион байгуулсан.<br>“Монгол хэл, бичгийн асуудал, шийдэл” үндэсний чуулганыг 2024 оны 01 дүгээр сарын 15-нд УИХ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Боловсролын ерөнхий газар, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их сургууль, Монгол Улсын Боловсролын Их сургуультай хамтран зохион байгууллаа.<br>2025 оноос Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл хангах хүрээнд Соёлын салбарын 41 байгууллагын 1027 албан хаагчид 64 удаагийн сургалт зохион байгуулж, салбарын хэмжээнд албан бичгээ хос бичгээр хөтөлж, 2024 онд нийт 2023 захирамжлалын баримт бичгийг хос бичгээр төлөвлөсөн.<br>**Төсөв 4,5 сая**<br>**Сургалт-2**<br>**Хамрагдсан байгууллага-26** | | |
| 9. | Арга хэмжээ 1.9. Хилийн чанадад дахь монгол иргэдэд хэл, соёлоо сурталчилж, монгол хэл, бичгийн сургалтын хэрэглэгдэхүүн цахимаар түгээнэ.<br>АХ-1.3, МУХТЖҮЧ 1.3, ЗГҮАХ-2.6.3.1 | Сургалтын хэрэглэгдэхүүн цахимд байршуулж нийтэд түгээсэн эсэх | Хилийн чанад дахь 60 сургалтын төвд 88 ном, 133 контент, цахим хэрэглэгдэхүүн хүргүүлсэн. | Цахим хэрэглэгдэхүүн -5 | Бүгд Найрамдах Итали Улсын Флоренцийн их сургууль болон Пармагийн их сургуульд Монголын соёлын төв байгуулагдаж, 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр нээлтээ хийсэн ба монгол хэл бичгийн сургалтын хэрэглэгдэхүүн төрийн албан хаагчдад зориулсан монгол бичгийн анхан, дунд, ахисан шатны унших бичиг 5, 18 цагийн цахим хичээл, монголчуудын хэрэглэж ирсэн бичиг үсгийн түүхийг таниулан сурталчлах цуврал 9 контент, монгол хэл бичгийн хэрэглээний гажуудлыг засах 30 контент, эх хэлний талаар ахмад үеийн үндэсний бичгээр гаргасан 10 цахим ном, монгол бичгээр компьютерт шивэх арга зүйн 66 зааварчилгаа, | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөр"-ийн хүрээнд Монгол Улсаас олон улсын, бүс нутгийн өвд бүртгэгдсэн 7 өвийн танилцуулга англи, монгол хэлээр бэлтгэснийг www.youtube.com/@Khosbichigten сувагт байршуулж, Гадаад дахь монгол соёлын төвүүдэд хүргүүлэв.<br>**Төв-2**<br>**Сургалтын хэрэглэгдэхүүн-140** | | |
| 10. | Арга хэмжээ 1.10. Монгол бичгээр хэвлэгддэг сонин, сэтгүүлд дэмжлэг үзүүлнэ.<br>АХ 2050-1.3, МУХТЖҮЧ-1.2,1.4, СТХ-8.5, СоЯ СТ-4.3 | Дэмжлэг үзүүлсэн сонин, сэтгүүлийн тоо | Уламжлал, Эх хэл бичиг сэтгүүл, Хүмүүн бичиг сонинд дэмжлэг үзүүлсэн. | Тушаал-1<br>Гэрээ-1 | Үндэсний бичгийн нийтийн хэрэглээний орчныг бүрдүүлэхээр улирал тутмын "Уламжлал" сэтгүүлд дэмжлэг үзүүлэх Соёлын сайдын 2024 оны 03 сарын 15-ны өдрийн "Зардал батлах тухай" А/101 тушаал батлуулж, Монгол бичгийн нийгэмлэг ТББ-тай 2024.03.22-ны өдрийн Соя-24/27 дугаар "Ажил гүйцэтгэх" гэрээ байгуулан тус сэтгүүлийн № 31-34 дүгээр дугаарт дэмжлэг үзүүлж, 4 дугаараас тус бүр 150 ширхгийг улс, нийслэл, аймгийн хэмжээнд нийтийн номын сан болон, сумын номын сангуудаар дамжуулан түгээж, үндэсний бичгээ сурталчлахын зэрэгцээ гарын авлага болгон түгээлээ.<br>**Сэтгүүл-1, (4 дугаар)**<br>**Төсөв-9,940.0** | 01.01-12.10 | 100 |
| 11. | Арга хэмжээ 1.11. Монгол хэл, бичгийн улсын уралдаан, тэмцээнд дэмжлэг үзүүлж, хамтран зохион байгуулна.<br>АХ-1.3, ЗГҮАХ-2.6.2.2 | Хамтран зохион байгуулсан уралдааны тоо | Мөнхтэнгэрийн бичиг ОУ уралдаан, Монголын сайхан бичигтэн | Уралдаан-1 | "Монголын сайхан бичигтэн" улсын 27 дахь уралдааныг дэмжин ажилласан. Тус уралдаан олон улсын хэмжээнд зохион байгуулагдаж, нийт 8 ангилалд 20 аймаг, Улаанбаатар хотын дүүргүүд болон БНХАУ-ын ӨМӨЗО, Япон, Чех улсаас нийт 1600 гаруй хүн оролцсон. Уралдааны хамгийн залуу оролцогч нь Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЕБС-ийн 2-ын "В" ангийн сурагч Э.Алтантулхуур, хамгийн ахмад оролцогч нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 1-р хорооны иргэн, Завхан аймгийн Алдархаан сумын уугуул 101 настай, ахмад багш С.Жигмэдсүрэн байв. Мөн Соёлын | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайдын 2022 оны А/322, 2023 оны А/298 дугаар тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эх хэлний боловсролыг дээшлүүлж, авьяас, ур чадварыг нээн хөгжүүлж, соёлын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэн, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 29 дүгээр тусгай сургуулийн сурагчдад монгол бичгийн "Уран бичлэгийн дугуйлан" хичээллүүлсэн ба тус дугуйлангийн сурагчид энэхүү уралдааны Нэрэмжит шагналын төрөлд “Ахмад дипломатч Г.Луузаны нэрэмжит шагналаар шагнагдсан.<br>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024.10.24-ний өдрийн А/82 тушаалаар “Мөнх тэнгэрийн бичиг” монгол уран бичлэгийн олон улсын үзэсгэлэн, уралдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн, үндэсний бичгийн соёлыг өвлөн уламжилж, түгээн дэлгэрүүлж буй сурагч, оюутан, насанд хүрэгчдийг урамшуулан, шилдэг бүтээлийн үзэсгэлэнг Монголын хүүхдийн ордны “Орд-Арт” галерейд дэглэж олон нийтэд танилцуулан мөн шилдэг бүтээлийн каталог хэвлүүлсэн.<br>**Төсөв 50,0 сая**<br>**Дэмжлэг үзүүлсэн уралдаан-2** | | |
| 12. | Арга хэмжээ 1.12. Үндэсний бичгийн цахим хичээлүүд, контентыг IPTV болон цахимд байршуулж, нийтэд түгээнэ. АХ-1.3, ЗГҮАХ-2.6.2.2 | IPTV-д байршуулсан тоо<br>Хандалтын тоо | “Хос бичигтэн” юүтүүб суваг нээсэн. | IPTV-д албан бичиг илгээсэн байна. | Иргэдийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх, үндэсний бичгийн нийтийн хэрэглээг дэмжих зорилгоор бүтээгдсэн үндэсний бичиг сурах 18 цагийн цуврал видео хичээл, компьютерт үндэсний бичгээр шивэх 66 заавар, монгол хэлний хэрэглээний гажуудлыг засах 30 контент зэргийг иргэд олон нийтэд түгээх зорилгоор олон сувгийн үйлчилгээ эрхлэгч ДДЭШ ТВ болон MNBC кабелийн тв-ийн Homemedia iptv-д үнэ төлбөргүй байршуулан иргэдэд түгээв.<br>**Ай Пи ТВ-2**<br>**Хандалт-1000**<br>**Төсөвгүй** | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13. | Арга хэмжээ 1.13. Утга зохиолын 7 хоног арга хэмжээ зохион байгуулна.<br>АХ-1.1, СТ-4.1.6, ЗГ-314 тогтоол | Арга хэмжээний тоо<br>Хамрагдсан хүний тоо | - | 5-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 2000-с доошгүй иргэн хамруулна. | "Утга зохиолын 7 хоног" арга хэмжээг зохион байгуулахаар сайдын 2024 оны А/119 дугаар "Зардал батлах тухай" тушаал батлуулсан. Арга хэмжээг 2024 оны 12 дугээр сарын 25-29-ний өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөж, "Монголын зохиолчдын эвлэл", "Уран зохиолын боловсролын төв" "Нандир" төрийн бус байгууллагуудтай Ажил гүйцэтгэх гэрээ байгуулав.<br>**Төсөв 50 сая** | 12.25-29 | |
| 14. | Арга хэмжээ 1.14. Болор цом-2024 арга хэмжээ зохион байгуулсан байна.<br>АХ-1.1, СТ-4.1.6, ЗГ-314 тогтоол | Хамрагдсан хүний тоо | Болор цом-2023 | Болор цом наадам зохион байгуулсан байна. | Соёлын бүтээлч сарын хүрээнд Оны шилдэг шүлэг шалгаруулах "Болор цом" 42 дахь удаагийн яруу найргийн наадмыг зохион байгуулахад Монголын Зохиолчдын эвлэлд 20 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Тус наадмыг 2024.11.26-ны өдөр Улсын филармонид зохион байгуулсан ба эхний шатны шалгаруулалтад 198 хүн шүлгээ ирүүлснээс хоёрдугаар шатанд 28 яруу найрагч шалгарч, түүнээс шилдэг тавд яруу найрагч На.Батболд, А.Лхагва, Д.Нямдорж, Л.Торой, Ч.Ууганбаяр нар шалгарч дэд байрт яруу найрагч Л.Торой шалгарсан бол На.Батболд гутгаар байрын эзэн болж, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт А.Лхагва "Морин хуурын хэл" шүлгээрээ тэргүүлж, "Болор цом"-ын эзэн болсон.<br>**Төсөв-20 сая**<br>**Хамрагдсан хүн-1000** | 11.26 | 100 |
| **Зорилт 2. "Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт"-ын хүрээнд** | | | | | | | |
| 15. | Арга хэмжээ 2.1. Хуулиар нийтлэг хүлээлгэсэн чиг үүргийн хүрээнд ажлын хэсэгт ажилласан байна. | Ажлын хэсэгт ажилласан эсэх | - | Ажлын хэсэг-1 | ➢ Чингисийн чулууны бичгийн 800 жил, Цогтын хадны бичиг буюу Дуутын хар чулууны бичээсний 400 жилийн ой тэмдэглэх ажлын хэсгийн нарийн бичиг,<br>➢ Боловсролын сайдын 2024 оны "Сургалтын | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, сурах бичгийн эх зохиох, хянах багийн бүрэлдэхүүн батлах тухай" А/06 тушаал, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирлын "Багийн бүрэлдэхүүн батлах тухай" тушаалаар Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах нийтлэг агуулгыг боловсруулах багт ажиллаж, СӨБ болон ЕБС-ийн бага ангийн сургалтын хөтөлбөрт тусгах соёлын агуулгад санал өгч ажиллалаа.<br>**Ажлын хэсэг-2** | | |
| 16. | Арга хэмжээ 2.2. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | Төлөвлөгөөний тоо<br>Тайлангийн тоо | - | Төлөвлөгөө-1<br>Тайлан -1 | ТАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, сар, улирлын тайлан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.<br>Үүнд: - Сар, улирлын тайланг тухай бүр бичиж холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн ажилласан Нийтлэг болон тусгай чиг үүрэгт хамаарах-Хууль тогтоомж, шийдвэрийн биелэлт-3, Алсын хараа-2050 МУ-ын урт хугацааны бодлогын баримт бичиг хэрэгжилт; Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-1 биелэлт; Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2.6.3.1.дэх заалтад хамаарах-1; - Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-20 биелэлт, Соёлын яамны стратеги төлөвлөгөөний стратегийн зорилт 4.1, 4.2 дахь заалтуудад хамаарах яамны болон газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тухай бүрд хүргүүлэв. Үндэсний бичиг соёлын жилийн тайланг харьяа байгууллага, соёл, урлагийн байгууллагуудаас авч нэгтгэсэн.<br>"Зөгийн үүр" хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, МУ-ын 2025 оны хөгжлийн төлөвлөгөө, "Миний монгол наадам" арга хэмжээний удирдамжийн төсөл, Соёлын элч нартай хамтран ажиллах төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж, Гадаад харилцаа, хамтын | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагааны хэлтэст хүргүүлсэн.<br>**Төлөвлөгөө-2**<br>**Тайлан-2** | | |
| 17. | Арга хэмжээ 2.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллана. | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны хэрэгжилт | - | Албан бичиг, өргөдөл хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж, ХОМ-ийг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдөр баталгаажуулсан. Мөн албан тушаалын нэр өөрчлөгдсөнтэй холбоотой тухай бүр ХАСХУМ мэдүүлсэн.<br>Тайлант хугацаанд албан бичиг, өргөдөл хүсэлтийн хугацаа хэтрэлтгүй, зохих журмын дагуу шийдвэрлэж, дараах захирамжлалын баримт бичгийг боловсруулсан.<br>Үүнд:<br>ирсэн бичиг-60<br>өргөдөл хүсэлт-3<br>явсан бичиг-22<br>Зардал батлах тухай тушаал-11<br>Ажлын хэсэг байгуулах тухай тушаал-2<br>Ажил гүйцэтгэх гэрээ-16 байгуулсан. | 01.01-12.10 | 100 |
| 18. | Арга хэмжээ 2.4. Цаг үеийн болон байгууллага, хамт олны дунд зохион байгуулагдаж буй арга хэмжээнд харьяалах нэгжийн албан хаагчдын хамт идэвхтэй оролцоно. | Арга хэмжээний тоо | - | Цаг үеийн ажлуудад оролцсон байна | ➢ Соёлын салбарын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөний үеэр зохион байгуулалтын багт ажиллаж, тараах материалын эх бэлтгэл, зөвлөгөөний хурлын тэмдэглэл хөтлөх зэрэгт ажилласан.<br>➢ Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл НҮТББ-ын 10 жилийн ойн чуулганд Эх хэл, түүх, өв соёлын боловсрол хэлэлцүүлэгт оролцож, соёлын яамнаас хилийн чанадад амьдарч байгаа монгол иргэдийн хэл, бичиг, соёлын баримталж буй бодлогын талаар санал солилцов.<br>➢ 2024.05.16-17-ны өдрүүдэд Сургуулийн өмнөх боловсролын багш нарыг Соёлын боловсролын багшаар бэлтгэх сургалт зохион | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулахад бэлтгэл ажлыг хангаж ажилласан.<br>➢ Монголын Үндэсний Номын сангийн шинэ барилгын нээлтийн арга хэмжээний бэлтгэлийг хангаж зохион байгуулах ажлын багт ажилласан.<br>➢ Нүүдэлчин наадмаар бэлтгэл хангах ажлын хэсэгт ажилласан.<br>➢ "Соёлын бүтээлч сар"-2024 дэд ажлын хэсэгт ажиллаж, хэлэлцүүлэг зохион байгуулсан. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. "Монгол ухаан, цээрлэх ёс" контентыг хийх байгууллагатай холбогдож гэрээ байгуулан гүйцэтгүүлэх | Өгсөн үүрэг даалгаврын биелэлт | - | Гэрээ байгуулж, дүгнэх | Соёлын сайдын 2023 оны "Зардал баталж, эрх шилжүүлэх тухай" А/474 дугаар тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны "Зардал батлах тухай" А/166 тушаалын дагуу "Супервижн медиа групп" ХХК–тай СоЯ-23/351 гэрээ байгуулан "Монгол ухаан, цээрлэх ёс" контентыг хийж гүйцэтгэх ажлыг гүйцэтгүүлэн гэрээг дүгнэсэн. Энэхүү нэвтрүүлгийг хүүхэд, гэр бүлд зориулсан нэвтрүүлэг, контентын тоог нэмэгдүүлэх, соёлын өвийг сурталчлах, эх орон, эх түүх, эх хэл бичгээрээ бахархах үзлийг нэмэгдүүлэх зорилгоор Угсаатан зүйн судлаач Бүрэнбаясах хөтөлж, Эмели хамтлагийн 8 гишүүн хүүхдүүд оролцож, монгол соёлын өв , цээрлэх ёсны талаар асуулт хариултын хэлбэрээр ярилцаж, хүүхэд багачуудад соёлын өвөө дээдлэх, уриалга үг хэлж, Монгол ухаан шүлгийг оролцогч хүүхдүүд уншиж сонирхолтой хэлбэрээр бэлтгэж, 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр SBN телевиз болон цахим хуудсаар шууд дамжуулан олон нийтэд түгээв. | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тайланг хүлээн авч гэрээ дүгнэсэн акт үйлдсэн. | | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. “Соёлын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн” соёл урлагийн байгууллагуудад тараах материал, даавуун тор, мандат, бичиг хэрэгслийн зүйлсийг хийлгэх байгууллагатай гэрээ байгуулах | Өгсөн үүрэг даалгаврын биелэлт | - | Гэрээ байгуулж, дүгнэх | Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын “Зардал батлах тухай” А/52 тушаалын дагуу “Соёлын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн”-ий үеэр оролцогчдод тараах материалын эх бэлтгэх, хэвлэх ажлыг “Галбилэг” ХХК-тай 2024.05.01-ний өдрийн СоЯ-24/89, даавуун тор хийлгэхээр “Нүүдэлчний соёл” ХХК-тай СоЯ-24/90, дэвтэр, бал, мандат хэвлүүлэхээр “Номун принт” ХХК-тай СоЯ-24/91 гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлж, гэрээ дүгнэсэн акт үйлдсэн. | 01.01-12.10 | 100 |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. "Гэр бүл- Монгол соёлын анхдагч орчин" арга хэмжээний хүрээнд Архангай аймгийн СУГ-т дэмжлэг үзүүлэх | Өгсөн үүрэг даалгаврын биелэлт | - | Тушаал батлуулж, дүгнэх | Гэр бүлийн орчноор дамжуулан соёлын боловсрол олгох “Гэр бүл-Монгол соёлын анхдагч орчин” сэдэвт эцэг, эх, хүүхдэд чиглэсэн олон талт сургалт, арга хэмжээг орон нутагт жишиг байдлаар хэрэгжүүлэхэд Архангай аймгийн Соёл, урлагийн газарт дэмжлэг үзүүлэхээр Соёлын сайдын 2024.05.03-ны өдрийн А/226 “Зардал батлах тухай” тушаалын төсөл боловсруулан батлуулсан. Ажил дүгнэсэн акт үйлдсэн. | 01.01-12.10 | 100 |
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Утга зохиолын шилдэг бүтээлийг шалгаруулан улсын санд худалдан авах, хадгалах, ашиглах ажлыг зохион байгуулах | Журмын хэрэгжилтийг хангасан эсэх | - | Журмын хэрэгжилтийг хангасан байна. | Засгийн газрын 2023 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын хэрэгжилтийг хангах хүрээнд Утга зохиолын шилдэг бүтээлийг шалгаруулан улсын санд худалдан авах, хадгалах, ашиглах ажлыг зохион байгуулахад шаардагдах 150,000,000.0 (нэг зуун тавин сая) төгрөгийг баталж, зарцуулах эрхийг ССАЖЗсайдын А/67 тушаалаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт шилжүүлсэн. Журмын дагуу Монголын зохиолчдын эвлэл нь утга зохиолын шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах талаар санал дүгнэлт гаргах, шалгаруулалт хийх эрх бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл нийт 9 хүний бүрэлдхүүнтэй байгуулагдаж, шилдэг бүтээл худалдан авах зарыг 10 сарын 03-наас 10 | 09.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сарын 09-ний өдрүүдэд зарласан. Шалгаруулалтад нийт 50 бүтээл ирүүлснээс журмын 2.1.2.тухайн онд зохион байгуулагдсан утга зохиолын уралдаан наадамд оролцож тэргүүн болон дэд байр эзэлсэн байх" гэх заалтад нийцсэн бүтээл ирүүлээгүй болно. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Байгууллага болон бусад газраас зохион байгуулсан сургалт, семинарт хамрагдана. | Сургалт, семинарт хамрагдсан эсэх | - | Мэдлэгээ дээшлүүлсэн байна. | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах" зааварчилгаа өгөх сургалтад хамрагдсан. | 01.01-12.10 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2. Монгол бичгийн компьютерт шивэх чадвараа дээшлүүлэх | Албан хэрэг хөтлөлтөө хос бичгээр хөтөлсөн эсэх | - | Албан хэрэг хөтлөлтөө хос бичгээр хөтөлсөн байна. | Яамны сайтад 22 "Онцлох мэдээ"-г монгол бичигт хөрвүүлэн цахим хуудсанд нийтэлсэн. Албан тушаал өөрчлөгдсөн өрөө тасалгааны хаягийг шинэчилсэн. Мөн Үндэсний бичиг соёлын жилийн төлөвлөгөө болон 7 албан бичгийг хос бичгээр боловсруулан, Үндэсний бичиг соёлын жил-2024 тайланг яамны харьяа соёл урлагийн байгууллагуудаас авч нэгтгэсэн. | 01.01-12.10 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

УТГА ЗОХИОЛ, НОМ ХЭВЛЭЛ, ЭХ ХЭЛ, БИЧГИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН А.АЛТАНЦЭЦЭГ (..........................) ........ ........ ..........
(Албан тушаал) (Нэр, гарын үсэг) (огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

# УТГА ЗОХИОЛ, НОМ ХЭВЛЭЛ, ЭХ ХЭЛ, БИЧГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН АДЪЯАЖАРГАЛЫН АЛТАНЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШНИЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам

Нэгжийн нэр: Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаа жуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлнэ.** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Үндэсний бичиг, соёлын жил-2024 арга хэмжээг салбарын хэмжээнд зохион байгуулна. | 60 | 10 | 70 | |
| 2. | Дэд арга хэмжээ 1.1.1. Үндэсний бичиг соёлын жилийг салбарын хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөө батлуулж, харьяа байгууллагууд болон аймаг нийслэлийн СУГ-т хүргүүлсэн байна. | 00 | 10 | 70 | |
| 3. | Арга хэмжээ 1.2. Үндэсний бичиг үсгийн баярыг зохион байгуулахад нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана. | 60 | 10 | 70 | |
| 4. | Арга хэмжээ 1.3. Эх хэлний өдрийг салбарын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлнэ. | 60 | 10 | 70 | |
| 5. | Арга хэмжээ 1.4. “Чингисийн чулууны бичиг” 800, “Цогтын хадны бичээс” буюу Дуутын хар чулууны бичээсний 400 жилийн ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулна. | 60 | 10 | 70 | |
| 6. | Дэд арга хэмжээ 1.4.1. Ажлын хэсэг байгуулж төлөвлөгөө боловсруулна. | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7. | Арга хэмжээ 1.5. Монгол хэл бичгийн сан хөмрөгийг баяжуулах “Мэдээллийн сан” байгуулна. | 60 | 10 | 70. | |
| 8. | Арга хэмжээ 1.6. Хүүхэд залуучуудын эх хэлний боловсролд зориулсан монгол хэл бичиг сурахад чиглэсэн аппликейшн шинэчлэн хөгжүүлнэ. | 60 | 10 | 70. | |
| 9. | Арга хэмжээ 1.7. Үндэсний бичгээр уламжлан ирсэн бичгийн дурсгалыг цахим хэлбэрээр түгээн, үндэсний бичгийн нийтийн хэрэглээний орчин бүрдүүлнэ. | 60 | 10 | 70. | |
| 10. | Арга хэмжээ 1.8. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3” хэрэгжилтийг хангаж ажиллаж, Хос бичигтэн байгууллага шалгаруулсан байна. | 60 | 10 | 70. | |
| 11. | Арга хэмжээ 1.9. Хилийн чанадад дахь монгол иргэдэд хэл, соёлоо сурталчилж, монгол хэл, бичгийн сургалтын хэрэглэгдэхүүн цахимаар түгээнэ. | 60 | 10 | 70. | |
| 12. | Арга хэмжээ 1.10. Монгол бичгээр хэвлэгддэг сонин, сэтгүүлд дэмжлэг үзүүлнэ. | 60 | 10 | 70. | |
| 13. | Арга хэмжээ 1.11.Монгол хэл, бичгийн улсын уралдаан, тэмцээнд дэмжлэг үзүүлж, хамтран зохион байгуулна. | 60 | 10 | 70. | |
| 14. | Арга хэмжээ 1.12.Үндэсний бичгийн цахим хичээлүүд, контентыг IPTV болон цахимд байршуулж, нийтэд түгээнэ. | 60 | 10 | 70. | |
| 15. | Арга хэмжээ 1.13. Утга зохиолын 7 хоног арга хэмжээ зохион байгуулна. | 60 | 10 | 70. | |
| 16. | Арга хэмжээ 1.14. Болор цом-2024 арга хэмжээ зохион байгуулсан байна. | 60 | 10 | 70. | |
| **Зорилт 2. “Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт”-ын хүрээнд** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Хуулиар нийтлэг хүлээлгэсэн чиг үүргийн хүрээнд ажлын хэсэгт ажилласан байна. | 60 | 10 | 70. | |
| 2. | Арга хэмжээ 2.2. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, | 60 | 10 | 70. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | | | | |
| 3. | Арга хэмжээ 2.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллана. | 60 | 10 | 70. | |
| 4. | Арга хэмжээ 2.4. Цаг үеийн болон байгууллага, хамт олны дунд зохион байгуулагдаж буй арга хэмжээнд харьяалах нэгжийн албан хаагчдын хамт идэвхтэй оролцоно. | 60 | 10 | 70. | |
| **Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт** | | | | | |
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. “Монгол ухаан, цээрлэх ёс” контентыг хийх байгууллагатай холбогдож гэрээ байгуулан гүйцэтгүүлэх | 60 | 10 | 70. | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. “Соёлын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн” соёл урлагийн байгууллагуудад тараах материал, даавуун тор, мандат, бичиг хэрэгслийн зүйлсийг хийлгэх байгууллагатай гэрээ байгуулах | 60 | 10 | 70. | |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. "Гэр бүл- Монгол соёлын анхдагч орчин" арга хэмжээний хүрээнд Архангай аймгийн СУГ-т дэмжлэг үзүүлэх | 60 | 10 | 70. | |
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Утга зохиолын шилдэг бүтээлийг шалгаруулан улсын санд худалдан авах, хадгалах, ашиглах ажлыг зохион байгуулах | 60. | 10 | 70. | |
| **Дундаж оноо:** | | | | 70. | |

2. **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. Байгууллага болон бусад газраас зохион байгуулсан сургалт, семинарт хамрагдана. | 10 | 10. | |
| 2. | Арга хэмжээ 2. Монгол бичгийн компьютерт шивэх чадвараа дээшлүүлэх | 15 | 15 | |
| **Дундаж оноо** | | | 12,5 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | | |
| 4. | Хариуцлагатай байдал | | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо** | | 8 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | 70. |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 12,5 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | 6 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 8. |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо:** | | 96,5/89 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

.....Сошхэб..... ......[signature]...... ....../Б. Довдонгорч/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

........................ *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Утга зохиол, ном хэвлэл, эх хэл, бичгийн асуудал хариуцсан мэргэжилтэн .............................. А.Алтанцэцэг

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

...................... *(огноо)*

***Үнэлгээг хянасан:*** *Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга .............................. Д.Түмэндэмбэрэл

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.13 *(огноо)*

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***

ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн .............................. Х.Даваасүрэн

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.13 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

Төрийн нарийн бичгийн даргын албан Үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. А.Даваажаргал

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

АТА12931 6594204 9024070548

......................... *(огноо)*